



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 5/69

Чингис хот

М.Урандолгионыг хөдөлмөрийн
гэрээгээр ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.2.2, 24 дүгээр зүйлийн 24.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулалт олгох журам”-ын 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөржүүлсэн бэлэн байдал зарлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 01 дүгээр зөвлөмжийн дагуу ажлын зайлшгүй шаардлагаар Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Үйлдвэр, хөдөө аж ахуй, хүнс, худалдаа, үйлчилгээний бодлого хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Мягмарбаатарын Урандолгионыг 2020 оны 7 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэм цуцлагдах хүртэл хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсугай.

2. М.Урандолгионы цалинг хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу 642388 /зургаан зуун дөчин хоёр мянга гурван зуун наян найм/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

3. Үйлдвэр, хөдөө аж ахуй, хүнс, худалдаа, үйлчилгээний бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг М.Урандолгионд үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР



231030265